



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 05

Номгон

“Газар зүйн танин мэдэхүйн товхимол”,  
“Орон нутаг судлал”-ын сурах бичиг, дасгал ажлын  
дэвтэр боловсруулах төсөл дэмжих тухай

Монгол Улсын гавьяат багш, сурган хүмүүжүүлэх ухааны доктор Шархүүгийн Чимгээгийн санаачилсан “Газар зүйн танин мэдэхүйн товхимол”, “Баянхонгор аймгийн орон нутаг судлал”-ын сурах бичиг, дасгал ажлын дэвтэр боловсруулах төсөл”-ийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь: “Баянхонгор аймгийн орон нутаг судлал”-ын сурах бичиг бий болсноор ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид орон нутгийнхаа газар, байгаль орчин, түүх соёл, хөгжил цэцэглэлтийн талаар танин мэдэхүйн мэдлэг, мэдээллээр хангагдаж, эх оронч сэтгэлгээ төлөвших, байгаль орчноо хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Газар зүйн танин мэдэхүйн товхимол”, “Орон нутаг судлал”-ын сурах бичиг, дасгал ажлын дэвтэр боловсруулах төслийг дэмжсүгэй.


2. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

2.1. “Баянхонгор аймгийн орон нутаг судлал” сурах бичиг, дасгал ажлын дэвтэр боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагааны зардал болон товхимол, сурах бичиг дасгал ажлын дэвтрийг хэвлүүлэх зардлыг аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагын хүрээнд боловсролын салбарт дэмжлэг үзүүлэхийг уриалж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж ажилласугай.

2.2. “Баянхонгор аймгийн орон нутаг судлал” сурах бичиг, дасгал ажлын дэвтрийг Ерөнхий боловсролын сургуулиудын Газар зүйн хичээлийн хөтөлбөрт оруулах ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлсүгэй.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



D:/2018/Alban bichig/TH togtool-2018

011:153